

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-13

1. Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 08 дугаар дүгнэлтийн тухай	3-13
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 11 дүгээр сарын 05-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 33 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Дэлгэрсайхан, М.Нарантуяа-Нара, У.Отгонбаяр,
Да.Цогтбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: С.Эрдэнэболд;
Тасалсан: Х.Баттулга.

Нэг.Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 08 дугаар дүгнэлтийн тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын ахлах зөвлөх Ж.Бямбадулам, С.Энхцэцэг, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Х.Баасанжаргал, Ж.Баярмаа, П.Сайнзориг, О.Номинчимэг, Д.Ганбат, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Уг асуудлыг 11 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 39 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 11 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
10 цаг 33 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Хуралдааны ирц 60 хувиар бүрдсэн байна.

Ирцэд орсон гишүүд. Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Оюунсайханы Алтангэрэл, Хүрэлбаатарын Баасанжаргал, Баярмагнайн Баярбаатар, Жудагийн Баярмаа, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Даваахүүгийн Пүрэвдаваа, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг гэсэн гишүүдийн ирцтэйгээр Сайнзориг, Номинчимэг гишүүн, Ганбат гишүүн ирцэд бүртгүүлсэн байна. Ингээд ирц 64 хувьтайгаар хурал эхэлж байна шүү. Ингээд ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Үндсэн хуулийн цэцийн 8 дугаар дүгнэлтийн тухай.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал нэрээ өгье. Алга байна.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 8 дугаар дүгнэлтийн нэгтгэн дүгнэх хэсэгт энэхүү дүгнэлт Үндсэн хуулийн цэцийн эцсийн шийдвэр бөгөөд Улсын Их Хурал энэ талаар хүлээн зөвшөөрөх, эсэх шийдвэр гаргахгүй гэж дүгнэсэн байна.

Иймд өнөөдрийн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэхгүй. Харин Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10.1-д заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд дурдсан асуудлыг хууль, эрх зүйн хувьд хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцэж, гишүүд саналаа хэлнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Нэрсээ өгнө үү. Номинчимэг гишүүнээр тасаллаа. Ингээд Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Хууль зүйн байнгын хорооны өнөөдрийн хурал дээр их сонин практик тогтох гэж байна. Цэцийн дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдагдсан 1 зүйлийг дурдаад, Улсын Их Хурал хэлэлцэхгүй гэдэг байдлаар шийдэх гэж байх шиг байна. Тэгэхээр Хууль зүйн байнгын хорооны дарга ер нь бол гишүүддээ лавлагаа гаргаад өгчхөөч. Хууль зүйн лавлагаа.

Үндсэн хууль дээр маш тодорхой заасан байгаа. 66 дугаар зүйлийн 2. Үндсэн хуулийн цэц нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хуралд оруулна гэж байгаа юм. Оруулсан зүйлийг яах тухай асуудал нь болохоор 20 дугаар зүйл дээр Улсын Их Хурлын бүрэн эрх дээр бичсэн байгаа. Тэгээд Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дээр маш тодорхой заасан байгаа. Дахиад. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж, эцсийн шийдвэр гаргана гээд биччихсэн байгаа. Үндсэн хуулийн энэ заалтыг яаж ойлгох вэ. Улсын Их Хурал хэлэлцээд, тэгээд зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хэлэлцэнэ гээд. 1, 2 гэдэг дотор нь юу байгаа вэ гэхээр 1-д нь Улсын Их Хурлын бусад шийдвэр гэж байгаа. Үндсэн хууль дээр маш тодорхой заачихсан. Тоочих аргаар Үндсэн хуулийн цэцийн хяналтын 4 объектыг заагаад тоочих аргаар заасан 1, 2 дахь асуудлыг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц их суудлаараа буюу дахин хянан үзээд шийдвэрлэнэ гээд заачихсан байгаа.

Өөрөөр хэлбэл яг 1, 2 дугаар асуудал дээр Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт бол эцсийн шийдвэр ерөөсөө биш. Улсын Их Хурлаар орж байж 1 бол Улсын Их Хурал хүлээж авбал эцсийн шийдвэр болдог. Хүлээж аваагүй бол Үндсэн хуулийн цэц өөрөө эцэслэн шийдвэрлэдэг. Үндсэн хуулийн бүр ийм заалттай. Энэ заалтыг дагуулаад, одоо хүчин төгөлдөр байгаа Цэцийн тухай хууль дээр 8 дугаар зүйл. Монгол Улсын Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84.2.хүчин төгөлдөр байгаа хуулиуд шүү дээ. Тэгээд энийг яах вэ. Яг энэ процедураараа бид ажиллахгүй бол бид дахиад л Үндсэн хуулийн маргаан руу очно. Хүссэн, хүсээгүй. Яг энэ маргаантай асуудлуудаа шийдэх бол Улсын Их Хурлын бүрэн эрх. Монгол Улсын гадаад дотоод бодлогын ямар ч асуудлыг санаачлан нь хэлэлцэх бөгөөд энэ дотроо бол хууль тогтоох эрх мэдэл нь байж байгаа.

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүнд нэмж 1 минут өгье.

Х.Тэмүүжин: Би 2, 3 зүйл хэлмээр байна. Асуудал яг Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудал дээр Хууль зүйн байнгын хороо энийгээ татаж аваад, ярьдаг байх хэрэгтэй байна 1 дүгээрт.

2 дугаарт гишүүдэд яг өнөөдөр хүчин төгөлдөр байгаа хууль тогтоомж болон Үндсэн хуулийн энэ зохих хэсгүүдээ лавлагаа байдлаар тараагаад өгчихдөг баймаар байна. Тэгэхгүй бол гишүүд хуулиа уншихгүй. Зүгээр дээгүүр хараад, хэвлэлийн мэдээ юм уу, эсвэл сошиал дээр байгаа мэдээгээр дамжуулаад яриад байна.

3-д нь ер нь бол хууль тогтоогчийн хувьд бол дахиад цааш нь сайжруулах, ойлголтоо тодорхой болгох, хууль тогтоох энэ чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх хэрэгцээнүүд бол байгаа юм байна гэж харагдаж байна. Энэ тухай Хууль зүйн байнгын хороо бас бүр нухацтай дахиад бүр хэлэлцүүлэг хийдэг юм уу, судлаачид, эрдэмтэд одоо юу байдаг юм хуульчдыг оролцуулаад өргөн бүрэлдэхүүнтэй ярилцах шаардлага бол байгаа юм шиг харагдаж байна.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Би өөрийнхөө ээлж ирэхээр бас өөрийнхөө байр суурийг энэ асуудлаар хэлнэ. Дараагийн хүн Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Хэлэлцэх асуудлыг сая хуралдаан даргалагч уншихдаа Үндсэн хуулийн цэцийн 08 дугаар дүгнэлттэй холбоотой асуудал гэж уншлаа. Тэгээд энэ дээр хэлэлцэх асуудал дээр би санал өгөөгүй. Учир нь гэвэл энэ дүгнэлтээр 2 асуудлыг шийдээд, дүгнэлт гаргасан.

1 дүгээрт Булгантуяа гишүүнийг Үндсэн хууль зөрчсөн асуудлаар,

2 дугаарт Засгийн газрын тогтоолыг 95 дугаар тогтоолыг.

Манай Хууль зүйн байнгын хороо өнөөдөр зөвхөн Булгантуяа гишүүний асуудлыг шийдэх гэж байна. Энэ нь өөрөө байж болох юм уу. 2 дахь дүгнэлтийн үр дагаврыг яагаад шийдэхгүй байгаа юм бэ. Өөрөөр хэлбэл 95 дугаар тогтоол өнөөдөр хүчинтэй байгаа юу. Хүчингүй байгаа юу. 95 дугаар тогтоол өнөөдөр хүчинтэй байгаа юу, хүчингүй байгаа юу. Үндсэн хуулийн цэц бол ийм дүгнэлт гаргахаараа, тогтоол, шийдвэр гаргахаараа хэрвээ эцсийн шийдвэр их суудлын хуралдааны шийдвэр гэж үзэж тогтоолыг хүчингүй болгож байгаа бол заавал энэ тогтоолыг хүчингүй болгосугай гэдэг зүйлийг заавал бичдэг байсан. Энэ удаа бичээгүй. Тэгэхээр Их хурал энийгээ хүчингүй болгох юм уу. Болгох ёстой гэж би бол хувьдаа харж байгаа. Бид нар Үндсэн хуулийн 66.3 дугаар зүйлийн дээгүүр нь алхаад, шууд 4-ийн мөрөөр одоо шийдвэр гаргах гээд сууж байна. Гэхдээ зөвхөн хувь хүнтэй холбоотой асуудлыг шийдээд, бусдын нүдээ аниад л өнгөрөх гэж байна л даа. Тэгэхээр ийм практик байж болох юм уу. Ийм зүйлийг бид нар хүлээн зөвшөөрөөд, тэр дундаа манай Хууль зүйн байнгын хороо чинь мэргэжлийн Байнгын хороо шүү дээ. Мэргэжлийн Байнгын хороо энэ дээр бол маш нухацтай авч үзэх ёстой.

Хэрвээ зөвхөн Булгантуяагийн асуудлыг шийднэ гэвэл 95 дугаар тогтоолыг автоматаар хүчингүй болсон гэж үзэх юм уу гэдэг нэг ийм болох гээд байна. Тэгэхээр ингээд үндсэндээ бол Их Хурлын Тамгын газар, Их хурал, чуулган, Байнгын хороод бол маш ийм тодорхойгүй нөхцөл байдалд орчихлоо л доо. Тэгээд бид нар энийгээ энд бол маш тодорхой яриад, шийдэл гаргаад явах ёстой.

Манай Байнгын хорооны дараа, Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдана. Тэгэхдээ Төрийн байгуулалтын байнгын хороо зөвхөн гишүүний асуудлыг хэлэлцэхээс бусдаар энэ дүгнэлтийн асуудлыг бас хэлэлцэхгүй. Дүгнэлтийн асуудлыг хэлэлцэхгүй. Энэ бол цэвэр мэргэжлийн Байнгын хорооны хэлэлцэх ёстой асуудал. Тэгэхээр энэ дээр бол манай Байнгын хороо бол маш хариуцлагатай байх ёстой.

2 дугаарт хэрвээ бид нар энэ удаа зөвхөн Булгантуяагийн асуудлыг хэлэлцээд, бусад асуудал нь Цэцийн дүгнэлтийн нэгтгэн дүгнэсэн хэсгийг манай дарга удирдлага болгоод байх шиг байна. Нэгтгэн дүгнээд хэрэгжүүлэх шаардлагатайг дурдах нь зүйтэй гэдэг энэ мөрөөр хэрвээ бид нар ажиллана гэх юм бол эргээд бид нар дахиад Үндсэн хууль зөрчөөд, 66.3-ыг хэрэгжүүлээгүй гэдэг ийм мөр лүү орох гээд байна. Тэгэхээр аль ч хувилбараараа байсан түрүүний Тэмүүжин гишүүн хэлсэн. Аль ч хувилбараар байсан дандаа бид нар Үндсэн хуулийн зөрчил рүү орох гээд байна. Энэ гацаанаас гарах хэрэгтэй. Гэхдээ энэ гацаанаас гарахдаа зөвхөн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд хөтлөгдөж бид нар гарахгүй. Дүгнэлт гаргах гээд 2 зүйл дээр дүгнэлт гаргасан. Энэ 2-ын үр дагаврыг бид нар хоёуланг нь манай Байнгын хороо шийдэх ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа.

Тэгээд одоо би юм асуухаар хэн хариулах юм бол. Цогтоо дарга хариулах юм уу. Хэн хариулах вэ. Ийм тодорхойгүй нөхцөл байдал үүсчихлээ.

Булгантуяа гишүүний асуудал дээр бол цэцийн дүгнэлт дээр ямарваа нэгэн байдлаар эргүүлэн татах асуудлыг огт дурдаагүй, хөндөөгүй учраас эргүүлэн татах ямар ч үндэслэл байхгүй гэдгийг бас хэлэх ёстой байх.

Д.Цогтбаатар: Энэ дээр Баасанжаргал гишүүн ээ, Үндсэн хуулийн цэцийн өмнөөс би бол хариулахгүй шүү дээ. Та өөрөө энийг сайн мэдэж байгаа. Тэгэхээр энд бид нар ямар ч гэсэн өөрсдийнхөө байр суурийг, би ч байр сууриа илэрхийлнэ. Ингээд л явахаас өөр гарц байхгүй. Энэ үнэхээр олон талаас нь бодож байгаад ийм шийдэл бид нар олж ирээд л ярьж байна. Тэгээд би нэгтгээд өөрийнхөө байр суурийг хэлнэ. Баярмаа гишүүнд микрофон өгье. Баасанжаргал гишүүнд 1 минут өгье.

Х.Баасанжаргал: Одоо асуултад хариулах хүн байхгүй бол би зориуд хурлын тэмдэглэлд үлдээмээр байгаа юм. Яагаад гэвэл энэ асуудал хожим нь судлагдана. Хожим нь судлаачид эрүүл саруул ухаанаар бас энэ нөхцөл байдлыг бүгдийг нь эргэж харах байх гэж бас найдаж байгаа. Тийм учраас Үндсэн хуулийн 66.3, Үндсэн хуулийн 66.4, дээрээс нь Их хурлын дэгийн тухай хуулийн 84, Их Хурлын дэгийн тухай хуулийн 85 гээд энэ заалтуудыг, энэ зохицуулалтуудыг бид нар зөрчөөд, өнөөдөр энэ хуралдаан үргэлжилж байна. Энийг яаж шийдэх вэ гэдэг дээр ямар ч шийдэл байхгүйгээр цаашаа явах гэж байна. Гэхдээ зөвхөн хувь хүнтэй холбоотой асуудлыг шийдэх ийм улс төрийн шийдвэр, улс төрийн акц хийгээд явж байна. Хууль зүйн хувьд бол бид нар үндсэндээ бүрэн гацаанд орсон гэдгийг хурлын тэмдэглэл тэмдэглэгчийн үлдээх хүсэлтэй байна.

Д.Цогтбаатар: Баярмаа гишүүнд микрофон өгье.

Ж.Баярмаа: Ерөөсөө цэцийн дүгнэлтийн тухай гээд биччихсэн ийм хурал болж байна. Тэгэхээр цэцийн дүгнэлтийн тухай яг юуг нь хэлэлцэх нь бас жоохон тийм тодорхойгүй. 95 дугаар тогтоол бол албан ёсоор хүчингүй болчихсон гэж ойлгож байгаа. Цэцийн шийдвэр их суудлын цэцийн шийдвэр гарлаа л бол автоматаар хүчингүй болоод, хэрэгжээд явчихсан. 95. Тэгэхээр 95 дугаар тогтоолыг хүчингүй болгох тогтоол дахиж гаргах гээд байгаа юм уу, үгүй юм уу. Би бас тэрийг ойлгохгүй байна. Хүчингүй болоод, дараагийнх нь үйл ажиллагаа нь явагдаад эхэлчихсэн.

Дахиад 1 асуудлыг ярихад бол 95 дугаар тогтоол чинь өөрөө ер нь эцсийн байдлаар хүчин төгөлдөр болсон байсан эсэх нь бас тийм байна. Яагаад гэвэл ердийн хууль гэж үзэх юм бол нөгөө төрийн мэдээлэл дээр гарснаас хойш 10 хоногийн дараа хэрэгжиж эхэлнэ гээд. Тэгэхээр процесс дуусаагүй байсан. Дээрээс нь Ерөнхийлөгч хориг тавьчихсан байсан гээд ийм юм яваад байгаа. Тэгэхээр 95-ыг бол дахиж хүчингүй болгох тухай юм бол яригдахгүй байх гэж бодож байна. Хэрэгжээд явчихсан учраас.

Дахиад энэ эхний хэсгийг нь аваад, тэр дүгнэлт хэсгийнхээ хавьд байгаа тйм ээ. Хүлээн зөвшөөрөх эсэх талаар хэлэлцэхгүй гээд. Тэгэхээр ерөөсөө Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиараа Үндсэн хуулийн дахиад 1 заалтаар бүх энэ дотор нь байгаа агуулга, бүрдэл хэсэг, салшгүй хэсэг гэж явж байгаа. Бүх үг, өгүүлбэр, үсэг. Тэгэхээр хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар хэлэлцэхгүй гээд энэ дүгнэлт дотор байгаа л бол хэлэлцэхгүй л гэсэн үг гэж харж байгаа юм. Яагаад гэвэл угаасаа бүрдэл хэсэг. Салшгүй хэсэг. Энэ дүгнэлт дотор байгаа бүх үг, үсэг, өгүүлбэр,

дүгнэлтийн салшгүй хэсэг гэж байгаа. Тэгээд тэрийг бас яах уу. Яах вэ, би заалтыг нь олоод хэлээд өгье. Ямар ч байсан тэрийг зөвхөн дүгнэлт нь хэлэлцэх ёстой асуудал мөн юм. Өмнөх тэр оршил бөгөөд тайлбар хэсгүүд нь бол биш юм гэсэн тийм хуулийн заалт байгаа юу. Тэгэхээр салшгүй хэсэг учир тэнд юу гэж заасан байна. Тэр бүгдийг бид нар тооцох ёстой гэж бодож байгаа. Тийм ч учир магадгүй тэр 9.3-аар хүлээн зөвшөөрсөн бол цаашаа ингэнэ гээд процедур заачихсан байгаа. Зөвхөн 9.3 биш, мөн Дэгийн тухай хуулийн нөгөө 85, 84.

Тэгэхээр хүлээн зөвшөөрөх эсэх тухай асуудлыг нэгэнт хэлэлцэхгүй юм бол дараагийн тэр шууд хэлэлцэх ёстой асуудал руугаа орох юм биш үү. Тэр асуудлууд нь ямар хуулиар, юу гэж заасан байгаа юм бэ. Тэр лүүгээ орох ёстой болов уу л гэж харж байна. Эгүүлэн татахтай холбоотой. Тэр Засгийн асуудалтай холбоотой нь бол тэртээ тэргүй 95 чинь хүчин төгөлдөр бус болоод, цаашаа үр дагавар нь гараад ингээд хэрэгжээд эхэлчихсэн явж байгаа гэж харж байгаа. Тэгэхээр ямар ч байсан тэр 95-ыг хүчингүй болгох тухай асуудлыг бол бид нар ярьж болохгүй байх. Дахиж тэртээ тэргүй тэр чинь хэрэгжээд хүчин төгөлдөр цэцийн шийдвэр шууд гармагц хүчин төгөлдөр болоод хэрэгжээд явчихсан.

Тэгэнгүүт Булгантуяатай холбоотой асуудлыг яах вэ гэхээр бусад тэр холбогдох хуулиудаар нь шийдээд явах байх. Дахиад бид нар албан тушаал нь огцруулах эсэх тухай асуудлыг энд бол ярих ёсгүй байх. Тэр бол бүлгийн шийдвэр. Тухайн бүлэг өөрөө дэд даргаас нь огцруулах эсэхээ шийднэ. Дахиад Их Хурлын тухай хуулийн 14 дээр байгаа шиг санаж байна. Шууд бүлгийн шийдвэр нь өөрөө Их Хурлын чуулган руу орох байх. Тэнд хүлээж авах эсэхийг олонхоороо шийдэх байх. Энд бол бид нар огцруулах эсэхийг бол ярихгүй. Эгүүлэн татах эсэхийг л ярина. Гэхдээ аль хуулиараа явах юм бэ. Нэгэнт хүлээн зөвшөөрөх эсэх тухай хэлэлцэхгүй юм чинь шууд эгүүлэн татах тухай асуудлыг хэлэлцэх юм биш үү гэсэн ийм л зүйл харагдаж байна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Бид хэд Үндсэн хуулийн цэцийн 08 дугаар дүгнэлтийг хэлэлцээд дахиад нэг Цэцийн маргаан руу л орох нөхцөл байдлыг л бүрдүүлээд байна. Өнөөдөр Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар маш ойлгомжгүй байдал үүсчхэж байгаа байхгүй юу. Яг яагаад байгаа нь мэдэгдэхгүй. Юу хэлэлцэх гээд ямар шийдвэр гаргах гээд байгаа юм. Тэгэхээр яг өнөөдрийн логикийн хувьд ийм байна. Монгол Улсын Үндсэн хууль дээгүүр хүчин чадалтай юу, Цэцийн дүгнэлт дээгүүр хүчин чадалтай юу гэдгийг дэнслэх гэж байна. Ямар ч үед Үндсэн хуулийг л бид дагаж мөрдөнө. Цэц ч гэсэн. Тэгэхээр өнөөдөр Цэцийн дүгнэлтийг бас зөв гэж хэлээд байгаа хүмүүст ганцхан зүйлийг л хэлмээр байгаа юм.

Уг нь бол үндсэн хуулийн тэр 66 дугаар зүйлийн 3 дээр маш тодорхой заачихсан. Дүгнэлтийг заавал Улсын Их Хурал хэлэлцээд, энэ Улсын Их Хурлын шийдвэрийг үндэслэж байгаад Цэц Цэцийн шийдвэр гаргаж болно. Энийг алгасаад 66.4-ийг хэрэглэх ямар ч боломж байхгүй. Энийг 1 дүгээрт хэлмээр байгаа юм.

2 дугаарт Үндсэн хууль бол нийгмийн гэрээ. Нийгмийн гэрээ буюу энэ гэрээний нэг тал нь ард түмэн байхгүй юу. Ард түмний төлөөлөл болоод Улсын Их Хурлын гишүүд сууж байгаа. Тэгэхээр энэ Үндсэн хуулийг манаж хамгаалах институт нь өөрөө парламент. Парламент нь өөрөө цаашдаа Үндсэн хуулиа ийм бүдгэрүүлж, Үндсэн хуулийнхаа үзэл санааг гуйвуулаад юу ч биш болгох гэж байгаад туйлын харамсалтай байгаа.

2 дугаарт сая Баярмаа гишүүн ч хэлж байна. Энэ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн агуулга гэж байдаг юм. 33 дугаар зүйл дээр байгаа. Цэцэд маргаан шийдвэрлэх гээд. Энэ дээр юу вэ гэхээр 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт дээр байгаа. 7 дугаар зүйл дээрээс эхлээд цэцийн хуралдааны хянан хэлэлцээд тогтоосон нөхцөл байдал гэдэг дээр л энэ нэгтгэн дүгнэлт хүртэл чинь явж байгаа юм. Үүнээс хойш яг энэ 33 дугаар зүйлийн 9, 10 дугаар зүйлд байсан удирдлага болгосон хуулийн заалт болон хэрхэн шийдвэрлэсэн бэ гэдэг заалт байгаа. Хоёрхон заалт. Булгантуяа даргыг Үндсэн хууль зөрчсөн байна. 95 чинь Үндсэн хуульд нийцээгүй байна гэдэг л шийдвэр. Бусад өмнөх зүйлүүдийг нь удирдлага болгож шийдвэр гаргах ямар ч боломжгүй байхгүй юу. Энэ шийдвэрийн агуулгыг чинь 33 дугаар зүйл дээр хэлээд өгчихсөн. Дээрээс нь Үндсэн хуулийн заалтаараа бид хэд энийг заавал авч хэлэлцэх ёстой. Хэрэвзээ нэг шийдвэр доторх 2 асуудлыг салгаж хэлэлцээд, нэгийг нь үлдээдэг жишиг үлдэх юм бол цаашдаа юу болох юм бүү мэд.

2 дугаарт би зүгээр шулуухан хэлье дээ. 95 хүчин төгөлдөр байгаа шүү. Засгийн газар үүрэг гүйцэтгэгч хэвээрээ байгаа. Хэрэвзээ бид нар 11 сарын 17-оос өмнө 95 дугаар тогтоолыг хүчингүй болгохгүй бол Улсын Их Хурал өөрөө тарах нөхцөл рүүгээ орно. Энэ 30 хоног дотор шинэ Ерөнхий сайдаа тавьж чадаагүй, эсвэл Цэц энийг нь хэлээд зас гээд байхад засахгүйгээр ингээд урагшлах гээд байгаа юм. Ерөөсөө Цэцийн шийдвэрийг эсэргүүцье гэдэг юм ярихгүй байгаа шүү дээ. Хүлээж аваад 95-ыг хүчингүй болгох процессыг нь хийчихье гэхээр эсэргүүцээд байгааг ерөөсөө ойлгохгүй байгаа байхгүй юу. Тэгээд Цэц зүгээр үндэслэх хэсэг дээр ингэсэн шүү дээ. 66 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг гэж заасныг хэрэгжүүлэх шаардлагатайг дурдах нь зүйтэй. Хэрэгжүүлэх гэдэг чинь хэлээд байна шүү дээ. Тэгэхээр үндсэндээ ийм нөхцөл байдал руу орлоо.

Энхбаяр сайд аа, би юм яриад байдаг. Ерөөсөө ингээд юм яриулахгүй юм. Цогоо дарга аа, дэгээ сахиулья. Тэгэх үү. Би давхцаж ярьж чадахгүй шүү дээ.

Д.Цогтбаатар: Гишүүд ээ., нэгнийгээ ярьж байхад битгий саад болоорой.

П.Сайнзориг: Тэгээд Булгантуяа даргын хувьд 1зүйлийг хэлмээр байна. 1 минутаа авчихъя.

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2021 онд туршчихсан байхгүй юу. Тухайн үеийн Ерөнхий сайд огцрох хүсэлт өгөхөд огцрох хүсэлт гэж байдаггүй юм байна аа. Энийг 43.1 дүгээр зүйлд зааснаар буюу гишүүдийн огцруулах байдлаар шийдэх нь зөв өө гээд байнгын хороо са одоо санал дүгнэлт гаргаад тэр санал дүгнэлтийн дагуу шийдсэн. Энэ өөрөө 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийг 2021 онд туршчихсан байхгүй юу. Тухайн үеийн Ерөнхий сайд огцрох хүсэлт өгөхөд огцрох хүсэлт гэж байдаггүй юм байна. Энийг 43.1 дүгээр зүйлд зааснаар буюу гишүүдийн огцруулах байдлаар шийдэх нь зөв гээд Байнгын хороо санал, дүгнэлт гаргаад, тэр санал, дүгнэлтийн дагуу шийдсэн. Энэ нь өөрөө 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийг ингэж хэрэглэх нь.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 минут.

П.Сайнзориг: Шийдчихсэн. 1 дүгээрт өөрөө Булгантуяа дарга Дэгийн хуулийг л барьж ажиллана. Дэгийн хуультай холбоотой Үндсэн хуулийн цэц дээр ямар ч маргаан байгаагүй. Маргаан байгаагүй. Маргаан байгаагүй энэ хуулийг удирдлага болгож, хурлыг даргалсныхаа төлөө өнөөдөр Үндсэн хууль зөрчсөн гэдэг бол энэ бол парламентын цаашдын дархлаанд маш ноцтой үр дагавар шүү. Үнэхээр бид хэд

энэ асуудлыг байсан бол эхлээд Дэгийн хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудал дээр эхлээд дүгнүүлчих байсан юм. Тэгээд дараа нь Булгаа даргын асуудал яригдах ёстой байсан байхгүй юу. Дэгийн хууль нь өнөөдөр хүчин төгөлдөр хэвээрээ буюу Үндсэн хууль зөрчсөн ямар нэгэн шийдвэр гараагүй байж байхад Булгаа дарга дээр алгасаад энэ асуудлыг нь ингээд шийдчихээд байгаа нь үнэхээр хардалт төрж байна.

Тэгэхээр энэ хэн дээр ч ирж болно. Сүүлдээ парламентын хурал даргалж байгаа хүн болгоныг ингэж хэлмэгдүүлж болохгүй шүү дээ. Тэгэхээр ийм л зүйл рүү явлаа. Тэгээд өнөөдөр хэлэхэд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буюу эцэслэн шийдэж байгаа шийдвэр дандаа хүчингүй болгосугай гэж гардаг. Энд хүчингүй болгох тухай яриагүй шүү. Хүчингүй болгох арга хэмжээг.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүн түр гарсан байна. Ганбат гишүүнд үг өгчихье.

Д.Ганбат: Бид нар чинь Үндсэн хуулийн дүгнэлтийг хэлэлцэж болохгүй шүү дээ. Энэ асуудлаа зөв томъёолоорой. Яг тэгж томъёолсон байна уу, юу байсан байна. Тэрийгээ анхаараарай. Тэгээд энэ Хууль зүйн байнгын хороо ер нь Улсын Их Хурал хуулиа сахидаг баймаар байна. Энэ асуудлыг, энэ дүгнэлтийг чинь ерөөсөө 7 хоногийн дотор л хэлэлцээд л нэг тийш нь болгочих л ёстой байсан шүү дээ. Ер нь хэлэлцэх ч биш л дээ. Тэр Үндсэн хуулийн хамгийн сүүлийн үг байгаа шүү дээ. Мэдэгтүн, сахигтун. Зүгээр л мэдүүлж байгаа Үндсэн хуулийг бол. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа Монгол Улсын иргэн, бусад харьяалалгүй хүмүүс, гадаадын иргэд бүгд л биелүүлэх ёстой шүү дээ. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гармагцаа хүчин төгөлдөр, их суудлаараа ийм л юм байгаа. Зүгээр л бид нарт мэдүүлж байна л гэж би ойлгож байна. 7 хоногийн доторх процесс нь явагдаж байна гэж үзэж байна. Тэгээд манай Хууль зүйн байнгын хорооны биш гишүүд ч гэсэн энэ дотор байж л байх шиг байна л даа. Мэдээж хэрэг байх эрхтэй л юм чинь.

Нөгөө Үндсэн хуулийг зөрчсөн яг нэрээр нь заачихсан байна шүү дээ. Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа гээд. Булгантуяа маань байх хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу. Үгүй ээ, тэгээд шөнөжингөө л алх бариад л нүдээд байсан шүү дээ. Би эхний өдөр, тэр 16-ны өдөр бол Үндсэн хууль зөрчих гээд байгаа юм байна гэж ойлгоод тэр хуралд нь суугаагүй. Ирц нь ч бүрдээгүй. Тэгээд л хараад байсан. 17-ны өглөө би хуралдаа ирсэн. Тэр больсон л байлгүй дээ. Анхааруулаад байсан шүү дээ. Үндсэн хууль зөрчиж болохгүй шүү гээд хэд хэдэн гишүүд ороод, ийм ийм бүр ялтай юм байна гээд ялыг нь хүртэл хэлээд байна лээ шүү дээ. Тэгээд өөрөө ч гэсэн дараа нь давтаж яриад л байна лээ. Хэн нэгэн Булгантуяадаа биш ээ энэ асуудал чинь. Энэ хулгай луйвар чинь хэтэрхий гаараад, тэгээд Үндсэн хууль үйлчлэхээ байгаад, бусад хуулиуд чинь үйлчлэхээ байгаад, үүний гор чинь гарч байгаа шүү дээ. Баахан тэр нүүрсний хулгайчид толгой дээр гараад суучихсан. Тэд нарын хам хамсаатан, тэд нарыг дэмждэг хүмүүс нь нэг талдаа гарчихсан. 10 жил эрх барьсан Ардын намын ялзрал ингэж л гарч байгаа шүү дээ. Ийм л байгаа. Битгий балайраад байгаарай. Хүн юм ярьж байхад хажуу талаас солиороод байх юм. Би юм ярьж байна. Чи яах гээд байгаа юм. Хуцдаг газраа хуцаарай. Яршиг л байна шүү зүгээр. Үгүй ээ, дарганцар болчихоороо ингээд байдаг юм уу. Яадаг юм. Нүүрсний хулгайчууд ийм л байгаа шүү дээ. Нүүрсний хулгайчуудын нэг хэсэг болчихоороо бүр толгой дээр гараад, яаж ч болно гээд бодчихсон. Чи Зам, тээврийн сайд яаж хийж байсныг чинь би мэднэ шүү дээ. Бүх Монгол Улсын төмөр замыг гацаагаад л үрчихсэн шүү дээ чи. Хэн гацаасан юм тэгээд. Одоо ямар байгаа билээ. Мухар төмөр зам тавьчаад, тэгээд л байж байгаа шүү дээ.

Д.Цогтбаатар: Нэгнийхээ үг хэлэх боломжийг олгоё.

Д.Ганбат: Монгол Улсыг ядуу дорой ийм байлгаж байгаа хэн юм. Та нар л биз дээ. Бид нар хэзээ эрх барьсан юм. Ардчилсан нам мөрөөрөө л байгаа шүү. Хэдэн үг хэлэх гэхээр бүр хэлүүлэхгүй. Үндсэн хуулийг зөрччихөөд одоо юу яриад байгаа юм бэ. Тэр Мэдэгтүн, Сахигтун гэж байгаа. Тэрийг хар. Булгантуяа чинь тэгээд алх бариад, нүдээд байсан биз дээ.../минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 минутыг гүйцээж өгье.

Д.Ганбат: Тэгээд та хэд хулгай луйвраа дотроо тэгээд тохироод ингэж явна гэж байхгүй. Бид нар лав зөвшөөрөхгүй. Монголын ард түмэн зөвшөөрөхгүй. Энэ чинь ямар үр дагавар дагуулаад байна вэ гэхээр парламент нэр хүндгүй болж байгаа. Монгол Улсын төр нэр хүндгүй болж байгаа. Эцэст нь бол хатуу гар мөрөөдөх тэр байдал руугаа оруулж байгаа. Та нарын тэр яриад байдаг дарангуйлагчийг бий болгож байгаа. Ийм юм руу л та нар явуулах гээд байгаа шүү дээ. Тэгээд бүр сүүлдээ асуудаг болчихсон. Манай тэр гишүүн тэгсэн юм. Манай нүүрсний талыг өмгөөлж байгаа. Тэр хүн Үндсэн хуулийг тэгж тайлбарласан гэж. Үндсэн хуулийг тайлбарлах эрх хэнд ч байхгүй шүү дээ. Зүгээр тэрийг мэд, сахь тэгээд л болоо шүү дээ. Цэцийн дүгнэлт гарчихсан байна. Энэ 9 гишүүн нь гарын үсгээ зурчихсан байна. Цэцийн тамга нь дараастай байна. Өөр юу хэрэгтэй юм. Монгол төрийн ажлыг гацаагаад иймэрхүү л байдалтай байгаа шүү дээ. Тэр өдөр тэгээд зөв орж ирээд, зөв суулгасан бол манай бүлгийн шийдвэр гарчихсан байсан.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Ер нь бол нөгөө эрүүл ухаан байхгүй газар хүчирхийлэл ихэсдэг гэдэг шиг л энд одоо юу болж байгаа, яг энэ цэцийн дүгнэлттэй холбоотой асуудлыг зарчмын байр суурины хувьд яаж хэлэлцэх ёстой юм гэдэг асуудлыг ярихаар хэн нэгний тал ч юм шиг, хэн нэгний улаан хамгаалагч ч юм шиг ийм дайрч доромжилдог байдал бол их гаарч байна. Сошиал дээр ч гэсэн. Тэгээд энэ дээр бол хувь хүний хувьд бас их харамсаж байгаа. Бид нар өнөөдөр яг үнэнийг хэлэхэд энэ цэцийн 38 хуудас дүгнэлт гарсан. Тэгээд дүгнэлт дээр орсон 1, 2 өгүүлбэрээс болоод ер нь энэ цэцийн дүгнэлтийг чи хэлэлцэх юм уу, хэлэлцэхгүй юм уу гэдэг асуудал өрнөөд, Үндсэн хуулиа хараад яг ийм гацаанд орчихсон байж байгаа байхгүй юу. Тэгээд өнөөдөр ч гэсэн гишүүд орж ирээд юу хэлэлцэх юм бэ гэхээр, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээ хэлэлцэх юм уу гэхээр үгүй, дүгнэлтийн тухай гэдэг юм хэлээд байхгүй юу. Энэ нь юу гэсэн ч үг юм. Тэгээд бид нар хэзээ нэгэн цагт энэ улс төрийн талцалд, тэмцэл, юу гэдэг юм дайралт давшилт дуусна. Энэ угаасаа л дуусдаг юм. Тэгээд ингээд дууссаны дараа бид нар энэ эрүүл ухаанаар энийгээ юу болчхов, яачхав гэдгийг үнэлэлт, дүгнэлт өгөх цаг ирнэ. Тэр үед энэ зарчмын байр суурь юу байсан юм бэ гэдэг маш чухал. Энэ чинь дараа нь ямар үр дагавар гаргах гээд байгаа юм бэ. Энийгээ л бид нар энэ мэргэжлийн Байнгын хорооны хувьд ингээд Хууль зүйн байнгын хороо уг нь хэлэлцэх ёстой байгаад байгаа юм.

Түрүүн бас гишүүд хэлсэн. Зарим гишүүдийн хувьд бол нөгөө Цэцийн дээр хөх тэнгэр гэдэг шиг л Цэцийн дүгнэлт дээр байж байгаа үг бүхнийг дагах ёстой гэдэг юм байх шиг байна. Хуульч бид нарын хувьд бол Цэцийн дээр Үндсэн хууль байдаг. Үндсэн хууль дээр цагаан дээр хараар 66.3 дээр Улсын Их Хурлын тэр тогтоол Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлтийг гаргаад, Улсын Их Хурал хүлээн

зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянаж үзэж, эцсийн шийдвэр гаргана гэдэг ийм үгтэй юм дүгнэлт нь. Тэгээд энэ манай нөгөө Цэц маань ямар процессоор нь явсан нь мэдэгдэхгүй нэлээн ийм яагаад ийм шийдвэр гарсныг би бол хувь хүний хувьд ерөөсөө ойлгохгүй байгаа. Тэгээд үүнээс болоод бид нар ямар дэгээр өнөөдөр бид нар юу хэлэлцээд байгаагаа ч ойлгохгүй байдалд хүрчихсэн байна шүү дээ.

Тэгэхээр энийг бол нэг тийш нь бас гаргасан нь зүйтэй. Дараа дараа энэ чинь 1 жилийн дараа, 5 жилийн дараа энэ маань өөрөө ямар үр дагавар үзүүлэх вэ гэдгээ бас бодож цөмөөрөө энийгээ хамтдаа шийдвэрлэсэн нь дээр гэж бодож байна. Өнөөдөр зарим гишүүд бол мэдээж энэ Цэц дээр бол 2 асуудлаар дүгнэлт гарсан. Бүгдээрээ мэдэж байгаа. Гэхдээ энэ дээр гишүүний эргүүлэн татах асуудлыг шууд хэлэлцэх ёстой юм биш үү гэдэг байр суурийг илэрхийлж байна. Энийг ч гэсэн бид нар хууль зүйн хувьд ямар ч боломжгүй юм. Манай зарим гишүүд бол мэдээж энэ дээр байр сууриа илэрхийлж байгаа. Гэхдээ тэр 38 хуудас дүгнэлтийг ер нь бүгдээрээ нэг ба, бэ-гүй уншчихмаар байгаа байхгүй юу. Сүүлийн 2 өгүүлбэрийг нь эсвэл дүгнэлтийг нь аваад бариад дайраад ингэчихсэн байна гэдэг юмыг сошиалд түгээхээсээ илүү.

Тэгээд Цэцийн энэ 38 хуудас дүгнэлтийг чинь 17 дугаар хуудсан дээр та бүхэн харах юм бол яг тэр Цэцийн Хурал болдог өглөө Засгийн газар талаас нэмэлт ийм шаардлага буюу нэхэмжлэлийн шаардлагаа ихэсгэсэн юм. Тэр дээр юу гэсэн бэ гэхээр Булгантуяа дэд дарга 6 дугаар хуудсан дээр байгаа юм байна шүү. Булгантуяа дэд дарга өөрөө өмнө нь бол нөгөө үйл ажиллагаатай холбоотой юм ярьж байснаа, өргөсөн тангаргаасаа няцаж ингэсэн гэдэг нэмэлт ийм шаардлага тавьсан байхгүй юу. Тэгээд энийг нь Цэц бол хэлэлцээд, шийдвэрлээд, баахан анализ хийгээд, тийм үндэслэл тогтоогдохгүй байна. Зөвхөн хурал даргалагчийн хувиар саналын буруу томъёолол уншаад, Үндсэн хууль зөрчсөн байна гэдэг шийдвэр нь гарчихсан юм. Тэгэхээр та бүхэн Үндсэн хуулийнхаа 29 дээр байгаа гишүүний тангараг ямар үед эргүүлэн татах үндэслэлийг харах юм бол энэ дээр өгүүлбэр нь гишүүний тангаргаасаа няцаж гэдэг үг байгаа. Манай Улсын Их Хурлын тухай хууль дээр ч байгаа. Энэ үгийг чинь болохоор Цэцэд чинь .../минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 минут өгье.

О.Номинчимэг: Цэц бол тийм үндэслэл тогтоогдохгүй байна. Даргалагчийн хувиар л ингэсэн байна гэдэг ийм шийдвэр гаргачхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр цөмөөрөө мэдээж улс төр явж байгаа байх. Гэхдээ энэ чинь дараа нь ямар үр нөлөөтэй байх юм бэ. Ингээд байх юм бол бүгдээрээ тэр 9.3 ч гэнэ үү няцсан гэдэг үг рүү оруулаад, Цэц тийм шийдвэр гаргаагүй байхад ингээд явах процесс руу битгий түлхээч ээ. Энэ маань өөрөө цааш цаашдаа том үр дагавар гаргана гэдгийг манай туршлагатай парламентчид уг нь бүгдээрээ л ойлгож байгаа байх гэж би найдаж байгаа. Тэгэхээр байр суурийн хувьд ийм байна.

Ер нь бид нар энэ цэцийн дүгнэлтийг яаж авч хэлэлцэх ёстой, ямар дэгээр яваад байгаагаа ч гэсэн ер нь тодруулчихсан нь дээр болов уу л гэсэн байр суурьтай байна.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Би хэдэн зүйл бас өөрийнхөө байр суурийг хэлнэ. Гишүүдийн ярьж байгаа зүйлтэй би олон зүйлтэй нь санал нэг байна. Гишүүд бол энэ дээр бас сэтгэл зовниж, бүгдээрээ л ажил хэргийн талаар санал тавьж байна.

Гэхдээ нэг зүйлийг хэдүүлээ ойлгоё. Сая сошиал контракт гээд нийгмийн гэрээ гээд л ярьж байх шиг байна. Сошиал контрактын аягүй олон хүн сошиал контрактыг ерөөсөө л Жан Жак Руссоттой холбож ярьдаг. Би энийг бүх эх сурвалжтай нь уншсан хүний хувьд нэг зүйлийг хэлмээр байна. Тэр Кант ч, Хобс ч, Жон Лок ч, Жан Жак Руссо ч энэ дээрээ хэлж байгаа нэг юм бол сошиал контракт бол бид нар тохироод, 1 хүлээгээд авчихсан бол тэрийгээ дагаж мөрдөнө гэсэн үг байгаа. Тэгэхээр өнөөдрийн энэ улсад Үндсэн хуулийн талаар Үндсэн хуулийн цэц оторити буюу шийдвэрээ гаргана гээд заачихсан байгаа. Бид биш. Бид хууль тогтооно. Бидний урдуур хэн ч орж ирж хууль тогтоохгүй. Бид нарын гаргасан хуулийг эцэслэж тайлбарлаад, их суудлынхаа юугаар гаргачихсан бол нийгмийн тохиролцоо чинь ахиад маргахгүй шүү гээд л энэ тохиролцоог хэлж байгаа юм.

Хэрэв Үндсэн хуультайгаа бид маргаад яваад байх юм бол энэ маргаан хэзээ ч дуусахгүй. 66.3-ыг яриад байна. Тэр 66.3-ыг яагаад хэрэглэж болохгүй байна гэхээр 66.3 чинь Их Хурал дээр нээрээ орж ирж хэлэлцээд, дараа дахиад хэлэлцэх боломж дунд суудлын хуралдаанаар шийдвэр гаргасан тохиолдолд Их Хурал дараа нь санал нийлээгүй байхад Үндсэн хуулийн цэц их суудлаараа шийдчихээд Их Хурал тэгээд л дуусдаг. Түүнээс Их Хурал эргээд ноцоод байдаггүй. Үндсэн хууль зөв, буруу гэдэггүй. Маргаан гарч байгаа талд одоо энэ шүүхийн практиктай зөндөө гишүүд байна. Маргаан гарч байгаа талд аль нэг талд нь шийдвэр гаргахад нөгөө тал нь хэзээ ч сэтгэл ханамжтай байдаггүй. Хууль буруу байна, энэ онцгүй байна, энэ тийм байна гэдэг. Гэхдээ бид нар шүүхийнхээ шийдвэрийг дагаад явна гэдэг нийгмийн гэрээтэй.

Тэгэхээр энэ дээр хүмүүс яриад байна. Энэ үндэслэл хэсэг дээр заасныг бид нар дагаж мөрдөөд байна гээд. Ерөөсөө жишээлбэл, барууны хууль ялангуяа би далайн эрх зүйтэй орнуудын 1 хууль аваад үзье. Аналоги юугаараа бусад хууль дээр адилхан хэрэглэгддэг шүү. Рэйшион десиденди гэдэг юм энэ үндэслэл хэсгийн гол шийдвэр гаргах суурийг гаргаж ирж байгаа логик тэр үндэслэл нь. Тэр Рэйшио Десидендийг чинь яг тэр агуулгаараа бол дараа дараагийнх нь шүүхүүд өөрийнхөө яг хэрэгцээтэй нөхцөлдөө аваад заавал ашигладаг юм шүү дээ. Энэ чинь өөрөө норм байхгүй юу. Тэгэхээр энэ ямар ч үр дагаваргүй гэж хэлэх ямар ч боломжгүй. Ялангуяа энэ дээрээ Үндсэн хуулийн цэц нөгөө бид нарын нийгмээрээ тохирчихсон энэ л эцсийн шийдвэр гаргана шүү гэдэг дээр хүлээн зөвшөөрөх эсэх талаар шийдвэр гаргахгүй шүү гээд хэлчихсэн байгаа байхгүй юу. Монгол хэлээр хоёргүй утгаар хэлчхээд байгаа юм.

Тэгэхээр бид нар Үндсэн хуулийн цэц буруу байна гээд ингээд хэлээд байх эрхийг бид нарт өнөөдөр хэн ч олгоогүй байгаа. Асуудал энэ дээр л. Үндсэн хуулийн харин тэр 66.3 чинь дунд суудлын юу байхгүй юу даа. Гэхдээ өнөөдөр яг бодит байдал дээрээ яг эргэж хэлэлцээд байгаа чинь л ерөөсөө энэ.

Одоо тэгэхээр би энэ дээр юу яримаар байна гэхлээр Үндсэн хуулийн цэц өөрөө ийм шийдвэр гаргачихсан. Үндсэн хуулийн цэцтэй маргамаар байгаа бол харин Тэмүүжин гишүүн маш зөв санал сая тавьж байна. Би ч гэсэн энэ асуудлыг бүгдийг нь уншиж үзээд, хамгийн түрүүн Баасандорж дарга энд сууж байна. Хамгийн түрүүн юу хэлсэн гэхээр энэ дээр бид нарт асуух асуулт, гүйцээж нөхөж гаргах хууль тогтоомжууд харин байгаа юм байна шүү. Энэ чинь бид нар ингээд төгс хууль хийдэггүй, хүн л юм чинь дутуу бодсон, амьдралд тооцоогүй өнцөг булангууд гарч байна. Тэгээд үүний дагуу бүхэл бүтэн ийм, ийм хуулиудыг энэ жишээн дээрээс ингэж янзлахгүй бол болохгүй юм байна гэдгээ гаргахгүй бол тэгээд тэрийгээ Их Хурал өөрөө засаад явах боломжтой байхгүй юу. Энэ эрх чинь харин бид нарт

байгаа шүү дээ. Тэгээд тэрийг хийнэ шүү гээд би Баасандорж даргад хэлчихсэн байж байгаа. Тэгээд энийгээ бол хийгээд явах байх. Би гишүүдтэйгээ санал нэг байгаа шүү.

Тэгээд 1 зүйл яамаар байна. Одоо энэ дээр яах аргагүй гишүүд ээ, нэг зүйл яримаар байна. Үндсэн хуулийн ингээд олон нийт ч ингээд ойлгочихсон байна лээ. Үндсэн хууль зөрчсөн бол шууд татна, эгүүлэн татна гээд. Тэгээд үгүй ээ, үгүй эгүүлэн татахгүй. Энд ийм ийм өшөө боломж байна гэхэд тэрийг Их Хурал л өөрөө шийднэ. Гишүүдийн ярьж байгаа гишүүдийн л байр суурь байхгүй юу. Үгүй ээ, би байр суурьтай байж болно биз дээ. Яагаад би өөрийнхөө үзэл бодолтой байгаагийнхаа төлөө юу яах ёстой юм. Гэтэл энэ дээр нэг асуудал байгаа шүү. Үндсэн хуулийн цэцийн нэг онцлог Резперденц есприденц маш багатай хууль. Жишээлбэл, 29.3. 30 жилд 2 удаа хэлэлцэгдсэн байхгүй юу даа. Резперденц маш багатай учраас гишүүд яг тэр асуудлаар маргаантай үедээ бол хэн нь ч хуулиа зөрчиж байгааг мэдэхгүй Үндсэн хуулийн зөрчил рүү орж магадгүй. Тэгээд бид нар эгүүлэн татаад байна гэх юм бол уучлаарай, сая төсвийн хууль хэлэлцэж байхад төсвийн хүрээний гадна шийдвэр гаргалаа, Үндсэн хууль зөрчлөө шүү гээд байхад хэчнээн олон гишүүн Yes гээд дарчихсан байгаа шүү дээ. Тэд нарыг буцааж татах уу. Тэр хүмүүс Үндсэн хууль зөрчсөн гэж бодоогүй байгаа шүү дээ. Яг тийм байхгүй юу. Тийм учраас энэ дээр Их Хурал шийднэ гээд. Тэгээд бид нар энийгээ Их Хурлаараа шийдэх гээд одоо орж ирээд ярьж байгаа чинь л энэ. Түүнээс ярихгүй болчихсон юм байхгүй. Ийм байдлаар бид нар өнөөдөр хэлэлцэж байгаа шүү.

Тэгээд үүнтэйгээ холбогдуулаад өнөөдөр нэгтгэн дүгнээд хэлэлцсэн асуудлаа хэлэхэд 2 зүйлийг хэлмээр байна.

1 дүгээрт Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах асуудлыг нэр дэвшүүлсэн нам, эвслийн бүлгийн хүсэлтээр шийдвэрлэхээр заасан бөгөөд Үндсэн хуулийн цэцийн 8 дугаар дүгнэлтийн 1 дэх хэсгийн хүрээнд Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг Үндсэн хууль зөрчсөн албан тушаалтныг Улсын Их Хурлын дэд даргыг огцруулах хүсэлтээ Улсын Их Хуралд оруулан, нэгдсэн хуралдаанаар шийдвэрлүүлэхээр байна.

2 дугаарт Цэцийн дүгнэлтийн 2 дахь хэсгийн хүрээнд Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдааны шийдвэрээр хүчингүй болсон Монгол Улсын Их Хурлын 2025 оны 95 дугаар тогтоолд холбогдох кодификац хийж, зарлан нийтэлж, мэдээлэх ажлыг хийх шаардлага үүсэж байгааг дурдах нь зүйтэй гэж Хууль зүйн байнгын хороо үзэж байна.

Ингээд өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууслаа. Ямар ч гэсэн бид нар энэ өнөөдөр болж байгаа нөхцөл байдлаа л дүгнээд, ийм байдалтай байна гээд Их Хурлын дэд даргын асуудал бол энд хэлэлцэхгүй байхгүй юу даа. Өнөөдрийн хурал ингээд хаалаа. Баярлалаа.

11.12 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ